



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



LOANS 3843/ 3844-MON AND GRANT 0672-MON

ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ – 1 ДҮГЭЭР ШАТ

**CS35: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМ,
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 17 ДУГААР ХОРООНЫ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН 19 ДҮГЭЭР ХОРООНЫ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН
ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫГ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРТ
ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА**

“Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл нь олон үе шаттай, Азийн хөгжлийн банкны (АХБ)-ны санхүүжилтээр өмнө нь хэрэгжүүлсэн анхан ба лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх хөрөнгө оруулалтын ажлын үргэлжлэл байдлаар Улаанбаатар хотын гэр хороололын иргэд, Ховд, Увс аймаг болон сонгогдсон сумын эрүүл мэндийн төв, дүүргийн эмнэлгийн дэд бүтэц, чадавхийг сайжруулах зорилготой. Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг дараах сайтаас хүлээн авна уу: <https://www.adb.org/projects/49173-003/main#project-overview>.

Төслийн хүрээнд дараах эрүүл мэндийн төв, байгууллагуудыг шинэчлэн барьж, Захиалагчийн хяналтыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж хүлээлгэн өгнө: Үүнд:

- i) Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ
- ii) Булган аймгийн Дашинчилэн СЭМТ
- iii) Баянзүрх дүүргийн 17-р хорооны ӨЭМТ
- iv) Чингэлтэй дүүргийн 19-р хорооны ӨЭМТ

Дээрх эрүүл мэндийн байгууллагуудын барилгын ажил 2023 оны 4 дүгээр болон 2024 оны 2 дугаар улиралаас эхлэх ба тус бүр 18 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Энэ зөвлөх үйлчилгээний үндсэн зорилго нь Монгол улсын барилгын тухай хууль тогтоомж, дүрэм, журам болон барилгын зургийн хүрээнд Захиалагчийн хяналтыг гүйцэтгэж, хүлээлгэн өгөхөд оршино.

Зөвлөх үйлчилгээг АХБ-ны худалдан авах журамд заасан Зөвлөхийн чадварын сонгон шалгаруулалтын аргаар үнэлж, шалгаруулна.

Сонирхсон этгээд АХБ-ны веб хуудсаар дамжуулан санал ирүүлэх хүсэлтээ илэрхийлэх ба байгууллагын чадавхи, холбогдох ажил, туршлагын талаарх мэдээлэлээ дэлгэрэнгүй оруулж, нотолгоо бичиг баримтуудаа хавсаргах шаардлагатай.

Ажлын даалгавар, төсөв болон байгууллагад тавигдах дэлгэрэнгүй шаардлагын талаарх мэдээлэлийг <http://cms.adb.org> (**Зөвлөх үйлчилгээний дугаар 192172**) холбоосоор орж авна уу. Төсөлд оролцох хүсэлтийг АХБ-ны <http://cms.adb.org> системээр **2023 оны 10 дугаар сарын 5-ны өдөрт** багтаан цахимаар ирүүлэх ба цаасаар ирүүлсэн материалыг хүлээн авахгүй.

Дэлгэрэнгүй мэдээлэлийг доорх хаягаар авна уу.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Засгийн газрын 8-р байр. Олимпийн гудамж
Эрүүл мэндийн яамны өргөтгөлийн байрны 3 давхарт 302 тоот өрөө
Холбогдох утас: 976-11-329369